



Нийгмийн даатгалын ерөнхий газар,  
Татварын ерөнхий газрын даргын  
хамтарсан 2023 оны ... дугаар сарын  
... –ны өдрийн ... дугаар тушаалын  
хавсралт

## ТАТВАРЫН АЛБАТАЙ ЦАХИМААР МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАН СОЛИЛЦОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.14.13, 37.16 дахь, Татварын ерөнхий хуулийн 13.3, 34.24 дэх заалтууд, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд тус тус заасныг үндэслэн Нийгмийн даатгалын болон Татварын байгууллага хооронд цахимаар мэдээлэл солилцох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Мэдээлэл солилцох хэлбэр, хугацаа

2.1.Нийгмийн даатгалын болон Татварын байгууллага нь энэ журмын нэгдүгээр хавсралтад заагдсан мэдээллийг цахимаар харилцан солилцоно.

2.2.Харилцан солилцож буй мэдээллийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан үндсэн систем /цаашид “үндсэн систем” гэх/-ээр дамжуулан солилцоно.

2.3.Мэдээлэл солилцохдоо Засгийн газрын “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ыг үндэслэл болгоно.

2.4.Мэдээллийг цахим хэлбэрээр солилцох боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хоёр байгууллага хоорондоо хэлэлцэн зөвшилцсөний үндсэн дээр тухайн мэдээллийг цахимаас бусад боломжтой хувилбарыг сонгон нөгөө байгууллагад хүргүүлнэ.

### Гурав. Хамтын ажиллагаа ба хяналт

3.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нь мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангаж, энэ журмын 2.3-д заагдсан үндсэн системээр дамжуулан солилцоно.

3.2.Солилцсон мэдээллийн үнэн зөв байдал, ашиглалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар, Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар тус тус хариуцан хяналт тавьж ажиллана.

3.3.Нийгмийн даатгалын байгууллага болон Татварын байгууллага нь хамтын үйл ажиллагааны явцад олж авсан байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ,

мэдээллийг албан хэрэгцээнд ашиглахаас бусдаар бусдад задруулахгүй бөгөөд хугацаагүйгээр нууцлах үүрэгтэй.

3.4.Цахимаар мэдээлэл солилцохоос бусад хамтын ажиллагааг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газрын хамтран баталсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр зохицуулна.

#### Дөрөв. Хариуцлага

4.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

ТӨСӨӨЛ

**Татварын ерөнхий газраас Нийгмийн даатгалын ерөнхий  
газарт хүргүүлэх мэдээллийн жагсаалт**

№	Харилцан солилцох мэдээлэл
1	Татвар төлөгчийн дугаар
	а/ Хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар
	б/ Иргэний 12 оронтой улсын бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаар
2	Хуулийн этгээдийн нэр
3	Татварын бүртгэлийн дугаар
4	Харьяалах татварын алба /дүүрэг, хороо/
5	Татвар төлөгчийн регистрийн дугаар
6	Татвар төлөгчийн овог, нэр
7	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар
8	Хариуцлагын хэлбэр, Бүртгүүлсэн огноо,
9	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (шууд бус орлого орсон дүнгээр) тайлан /Маягт ТТ-11 тайлангийн ТТ-11(1), ТТ11(4) хавсралтын дүн/
10	Ажиллагчдын тоо
11	Ногдуулсан татварын нийт дүн. Үүнээс:
12	а/ ажил олгогч
13	б/ татвар төлөгч
14	Үйл ажиллагааны чиглэл, хаяг байршил
15	Удирдлагын мэдээлэл

**Нийгмийн даатгалын ерөнхий газраас Татварын ерөнхий газарт  
хүргүүлэх мэдээллийн жагсаалт**

№	Харилцан солилцох мэдээлэл
1	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн дугаар
	а/ Хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар
	б/ Иргэний 12 оронтой улсын бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаар
2	Хуулийн этгээдийн нэр
3	Нийгмийн даатгалын бүртгэлийн дугаар
4	Харьяалах нийгмийн даатгалын хэлтэс
5	Даатгуулагчийн регистрийн дугаар
6	Даатгуулагчийн овог, нэр
7	Даатгуулагчийн бүртгэлийн дугаар
8	Даатгуулагчийн төрөл
9	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /Маягт НД7, НД8 тайлангийн дүн/
10	Ногдуулсан шимтгэлийн нийт дүн. Үүнээс:
11	а/ ажил олгогч
12	б/ даатгуулагч